



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 11 сарын 13 өдөр

Дугаар А/451

Улаанбаатар хот

**Сүхбаатар дүүргийн 3 дугаар  
сургуулийн данс бүртгэлд  
хөрөнгө бүртгэх тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгдчийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 10,140,000 /арван сая нэг зуун дөчин мянган/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Сүхбаатар дүүргийн 3 дугаар сургууль /В.Хоролгарав/-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сүхбаатар дүүргийн 3 дугаар сургууль /В.Хоролгарав/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны 11 сарын 13 өдрийн 4/УС/ дүгээр тушаалын хавсралт

1119282485.04.2076539

Бүртгэлд авах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сүхбаатар дүүргийн 3 дугаар сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар, үзүүлэлт	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн анхны		Хандивлагч байгууллага	
						Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Нэр	Эх үүсвэр
1	Сурагч ширээ сандал /хос/	модон	2019	ш	52	195,000	10,140,000	Эцэг эхчүүд	Хандив
							10,140,000		
							10,140,000		
Тавилга, эд хогшлын дүн НИЙТ									